

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН НИЙСЛЭЛИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2026.02.25.

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	2	3
1	Дэд зөвлөлийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны төлөвлөгөөг батлуулан. ОУИТБС-н ажлын албанд хүргүүлэн вэб сайтад байршуулах.	Тус зөвлөлөөс 2025 онд 5 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг батлуулсан. Мөн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг биелэлтийн тайланг гарган ОУИТБС-н ажлын албанд хугацаанд хүргүүлж холбогдох вэб сайтад байршуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Хэрэгжилт 100%
2	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй байгуулсэн гэрээнүүдийг Ил тод байдлын /iltodgereee.mn/ сайтад байршуулах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 аж ахуйн нэгжүүдтэй байгалийн гамшгийн үед шаардлагатай элс, дайрга, хайрга нийлүүлэх гэрээг 2025 онд байгуулж хамтран ажилласан. Дээрхи гэрээг 30 аж ахуйн нэгжийн гэрээнүүдийг /iltodgereee.mn/сайтад байршуулж ажилласан. Хэрэгжилт 100%
3	Түгээмэл тархацтай ашиглалт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг https://cmcs.mrpam.gov.mn/ https://beneficialowner.mn/ сайтууд болон олон нийтэд ил тод байршуулах	Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын 137 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг олон нийтэд ил тод байршуулахаар нарийвчилсан судалгааг гаргаж байгууллагын сайтад байршуулсан. Үүнээс 2025 онд 42 аж ахуйн нэгжүүд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байна. Хэрэгжилт 100%
4	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашиглалтын үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 52 аж ахуйн нэгж 25.1 га талбайд 160.5 сая.төг-өөр газрын хэвлийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэхээр ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулсан. Үүнээс 11 аж ахуйн нэгж 10,34 га техникийн болон биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэхээр 13.8 га талбайн тус тус нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлсэн. Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2025 онд нийт 25 аж ахуйн нэгжийн

		байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлагдсан дагуу 22 аж ахуйн нэгжүүдийн тайланг хянаж дүгнэв. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дүйцүүлэн хамгааллын хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 52 аж ахуйн нэгжүүд 2025 онд Тэрбум-мод хөдөлгөөний хүрээнд мод тарих, булгийн эхийг хашиж хамгаалахаар төлөвлөсөн. Тус ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр улсын 2 дугаар эмнэлэг орчмын нийтийн эзэмшлийн 866 мкв талбайн ногоон байгууламж бий болгож, 270 ширхэг гүйлс, нарс модыг тарив, Хан-Уул дүүргийн 12, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Гавьжийн шандын булаг, Булгатай булгийн эхийг хашиж, хамгаалав. Хэрэгжилт 100%
5	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгөх ажлыг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албатай хамтран гүйцэтгэх	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан томоохон 12 мега төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бүтээн байгуулалтын ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд барилгын материалын түүхий эдийн хэрэгцээ нэмэгдэх төлөвтэй байна. Иймд нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал (дайрга) олборлогч 50 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй 2025 оны 02 дугаар сарын 04-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Хэрэгжилт 70%
6	Төлөвлөгөөний хэрэгжилтийн нийт хувь	94%

Нийслэлийн байгаль орчны газар